2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.01.27 Дугаар 17

| № | Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга | Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан | Биелэлт ирүүлэх хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар аймгийн хэмжээнд өндөр тархалттай байгаа тул байгууллагынхаа 0-5 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудыг цахимаар ажиллах боломжоор хангах | Нийт байгууллага, агентлаг | I/27 | **ОНӨГ:** Ажлын ачаалал их байгаа тул цахимаар ажиллуулах боломжгүй болно.<br>**ЦШСГ, БОАЖГ, ТХ:** Байгууллагын 0-5 настай хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудыг богиносгосон цагаар ажиллуулж байгаа болно.<br>**МХГ:** 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудад 2 цагийн цалинтай чөлөө олгож, өдөрт 6 цаг ажиллуулж байна. Ажлын онцлогтой холбоотой цахимаар ажиллуулах боломжгүй.<br>**УБХ, БГ, УЦУОШГ, ХХААГ, СХЗХ, ГХБХБГ, БТСГ:** 0-5 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудыг цахимаар ажиллах боломжоор ханган ажиллаж байна.<br>**АНЭ:** 110 гаруй эмч ажилчид 0-5 насны хүүхэдтэй бөгөөд эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс цахимаар ажиллуулах боломжгүй байна.<br><br>**ХХҮГ:** 0-5 настай хүүхэдтэй 10 эмэгтэй ажилтан байгаа бөгөөд үүний 2 нь гэрээр цахимаар ажиллаж байгаа. Үлдсэн албан хаагчид нь ажлын зайлшгүй шаардлагаар хэвийн горимоор ажиллаж байгаа болно.<br><br>**ОБГ:** Алба хаагчдыг тусгай горимоор ажиллуулж байна. |
| 2 | Өлгий сумын Шипагер, Жансая өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ачааллыг бууруулах болон Сансар сувиллын үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор нэмэлтээр ажиллуулж болох барилгуудын нөхцөл байдалтай танилцах, дүгнэлт гаргах | ХЭЗХ-н дарга Ө.Хуралай<br>ЭМГ-ын дарга Н.Сакен | I/27 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ачааллыг бууруулах болон Сансар сувиллын үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор нэмэлтээр ажиллуулж болох барилгуудын нөхцөл байдалтай танилцаж дүгнэлт гаргасан. Дүгнэлтийг аймгийн ЗДЗ-д танилцуулахаар бэлэн болгосон. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Төрийн албаны Зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн тогтоолын дагуу байгууллагынхаа түр томилогдсон ажилтнуудыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлөх арга хэмжээ авах үүргийг биелүүлээгүй албан тушаалтнууд дээрхи үүргийн биелэлтийг хангаж ажиллах | Нийт байгууллага, агентлаг | I/27 | **Татвар:** Сул орон тооны захиалгыг ТАСЗ-д хүргүүлсэн. Цагааннуур тосгоны татвар хураагчийг Б/01 тушаалаар ажлаас чөлөөлсөн.<br><br>**ОНӨГ:** Сул орон тооны захиалгыг ТАСЗ-д хүргүүлсэн.<br><br>**ЦШСГ, МХГ, УБХ, ХХААГ, ГХБХБГ,ОБГ** : Чөлөөлөгдөх албан хаагч байхгүй.<br><br>**МЭГ:** Аймгийн төвд улсын байцаагч 1, Ногооннуур сумд 1 тархвар зүйч, Алтай сумд 1 тархвар зүйч ерөнхий шалгалт өгөөгүй. Албан хаагчдыг ажлаас чөлөөлөхөд хүндрэлтэй байна.<br><br>**СХЗХ:** Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс сул орон тоог хууль журмын дагуу нөхөх хүртэл баталгаажуулалтын шинжээчийн албан үүргийг гэрээгээр түр орлон гүйцэтгэж байсан ажилтныг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/19 тушаалаар ажлаас чөлөөлсөн болно. Хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтний сул орон тоог нөхөх зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр шинээр батлагдсан албан тушаалыг тодорхойлолтыг Төрийн албаны салбар зөвлөлд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дахин хүргүүлэн Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>**ХХҮГ, БОАЖГ:** Мэдээллийг албан тоотоор ТАСЗ-д хүргүүлсэн болно. |
| 4 | Аймгийн Онцгой комиссын тохиолдлын удирдлагын багуудыг шинэчилж, үйл ажиллагааг жигдрүүлэх арга хэмжээ авах | ОБГ-ын дарга З.Азат АШШтаб | I/27 | Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 85 дугаар тушаалаар баталсан бүтцийн дагуу аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын тохиолдлын удирдлагын тогтолцооны 5 багийг аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/855 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Багийн ахлагч нарт үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэл хүргүүлсэн. |
| 5 | Байгууллагынхаа ил тод байдлын мэдээллийг вебсайтад хугацаанд нь, тухай бүр бүрэн байршуулах арга хэмжээ авах | Нийт байгууллага, агентлаг | I/27 | Байгууллагын ил тод байдлын мэдээллийг вебсайтад хугацаанд нь, тухай бүр бүрэн байршуулах арга хэмжээ авч ажиллаж байна гэх биелэлтийг ТХ, ЦШСГ, МХГ, УБХ, УЦУОШГ, АНЭ, СДОА, ХХААГ, СХЗХ, ХХҮГ, ГХБХБГ, ОБГ, БОАЖГ-аас ирүүлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | **ӨНӨГ**: Вебсайтыг шинэчлэх, дуудлага худалдааны сайтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. |
| 6 | 2022 оны үүл буудах ажлыг эртнээс төлөвлөж, үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авах | УЦУОШГ-ын дарга П.Жанаргүл | I/27 | 2022 оны 16 тоот албан бичгээр 30ш пуужин, 24ш түлш олгож өгөх тухай хүсэлтийг ЦУОШГазарт хүргүүлсэн. |
| 7 | Томуу, томуу төст өвчний цаг үеийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээ, сэрэмжлүүлэг мэдээг орон нутгийн телевиз, радио хэрэгслээр мэдээлэх арга хэмжээ авах | ЭМГ-ын дарга Н.Сакен<br>АНЭ-н дарга Х.Манчук | I/27 | **АНЭ:** Коронавируст халдвартай хэвтэн эмчлүүлэгчийг 50 ортой хүүхдийн эмнэлгээс мэдрэлийн тасагт нүүлгэн шилжүүлсэн, ариутгал халдваргүйтгэл, их цэвэрлэгээ хийлгэсэн ажлын талаар болон эмнэлгээр үйлчлүүлсэн үед халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн баримтлах тухай ярилцлагыг орон нутгийн Дербес телевизээр НЭ-ийн дарга Х.Манчук, хүүхдийн тасгийн эрхлэгч К.Аяужан, халдвар судлаач эмч н.Алемгүл нар өгсөн болно. Мөн томуу, томуу төст өвчин ихэссэнтэй холбоотой Нэгдсэн эмнэлгийн фэйсбүүк пэйж хуудсаар өдөр болгон томуу, томуу төст өвчний ерөнхий ойлголтын талаарх мэдээллүүдийг оруулж байна. Мөн Орон нутгийн радиогоор 1 удаа, Саян телевизээр 1 удаа урьдчилан сэргийлэх, хүндрэлээс сэргийлэх зэрэг сэдвүүдээр НЭ-ийн нийгмийн ажилтан М.Елик мэдээлэл түгээж ажилласан болно. |
| 8 | Аймгийн хэмжээний бүх тендерийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зарлах, 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гэрээ хийж, ажлыг эхлүүлэх | ХОХБТХ-н дарга Х.Анар<br>ГХБХБГ-ын дарга К.Болат<br>ОНӨГ-ын дарга Т.Назым | III/01 хүртэл | **ОНӨГ:** 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын 6 тендер болон бусад байгууллагаас эрх шилжиж ирсэн 2 тендерийн сонгон шалгаруулалтыг цахимаар зарласан болно.<br>**ХОХБТХ:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн 21 төсөл арга хэмжээний 10 ажлын зураг төсөл, техникийн нөхцөлийг орон нутгийн өмчийн газарт хүлээлгэж өгсөн. Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авах шууд гэрээ хийсэн. Эрчим хүчний 2 ажлын зураг төслийг гүйцэтгэгч компани тухайн төслийн талбайд хэмжилт хийн ажиллаж байна. Ногооннуур сумын 2-р багийн 160 суудалтай бага сургууль, 30 ортой дотуур байр, Алтанцөгц сумын 100 ортой сургуулийн дотуур байрын зураг төслийг “АЕСН” ХХК , Өлгий сумын 5-р багийн 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ортой цэцэрлэгийн барилгын зураг төслийг "Премиум проект" ХХК, Өлгий сумын 1-р багийн цэвэр усны шугам татах ажлын зураг төслийг "Чулуутын багш" ХХК, Алтай сумын хатуу хучилттай авто зам, Улаанхус сумын Хөх хөтөл багийн Бетон гүүрийн ажлын зураг төслийг "Кадсүрвэй" ХХК, Алтанцөгц сумын хатуу хучилттай авто замын ажлын зураг төслийг "Ихэрмөнх" ХХК тус тус гүйцэтгэж байна.<br>**ГХБХБГ:** Шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн 8 арга хэмжээний нэг ажлын зураг нь магадлалд орсон. 4 ажлын тендер зарлагдсан. 2021 онд гарсан зөрчил, ололтыг дүгнэж 2022 оны төсөл арга хэмжээний талаар 02 дугаар сард багтааж барилгын компаниудтай удирдах ажилтны зөвлөгөөн хийхээр төлөвлөж байна. |
| 9 | Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулах | ХОХБТХ-н дарга Х.Анар<br>Ойн ангийн дарга Х.Есенбол | I/27 | **ХОХБТХ:** "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Сум дундын ойн анги боловсруулан ирүүлсэн бөгөөд хянаж байна.<br>**СДОА:** Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргад хүргүүлсэн болно. |
| 10 | Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний явцын талаарх мэдээллийг радиогоор нэвтрүүлэх | ОНОНРТА-ны дарга Н.Оспан | I/27 | Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний явцын талаарх мэдээллийг аймгийн радиогоор 2022.01.24-ний өдөр нэвтрүүлсэн болно. |
| 11 | Яамдын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлүүлэх боломжтой байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг холбогдох яамд албан бичгээр уламжлах, аймгийн Засаг даргын сайдтай байгуулах гэрээнд тусгуулахаар санал хүргүүлэх | Нийт байгууллага, агентлаг | I/27 | **ГБХЗХГ-**Тус газрын зүгээс салбарын сайдын багцаас шийдвэрлүүлэх асуудлын санал гараагүй тул сайдад уламжлаагүй болно.<br>**ЦШСГ,МХГ, УБХ, УЦУОШГ, СХЗХ, ГХБХБГ, ОБГ, ОНӨГ:** Сайдтай байгуулах гэрээнд тусгуулахаар санал хүргүүлсэн.<br>**БГ:** Вебсайтыг шинэчлэх ажил хийгдэж байна.<br>**ХХААГ:** Яамдын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлүүлэх боломжтой байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг холбогдох яамд албан бичгээр уламжлах талаар санал боловсруулж байгаа.<br>**ХХҮГ:** Байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудалтай холбоотой саналыг албан тоотоор |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ХНХ дэд сайдад хүргүүлэв.<br>**БТСГ:** Спорт цогцолборт их засвар хийхэд шаардлагатай төсвийн төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, аймгийн Засаг даргын Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргатай байгуулах гэрээнд тусгуулахаар санал хүргүүлсэн.<br>**БОАЖГ:** БОАЖСайдтай 2022 онд байгуулах гэрээнд тусгах саналыг ХОХБТХ-ээр дамжуулан Засаг даргын зөвлөлд оруулж, БОАЖЯ-д хүргүүлэв. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР